**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөдөө аж ахуйн корпораци ТӨХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** САГ-2026/82/НА-СТА-ТӨҮГ


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2026 он | Санхүүгийн аудитын газрын захирал,<br>тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг<br>Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn<br>Аудитын менежер: Э.Энхбаатар<br>Утас:  Цахим хаяг: Enkhbaatare@audit.gov.mn<br>Ахлах аудитор: П.Батцэцэг<br>Утас: Цахим хаяг: Battsetsegp@audit.gov.mn<br><br>Аудитор: Пийк ОМ Аудит ХХК-ийн захирал Б.Жаргалсайхан<br>Утас: 99862066 Цахим хаяг: peakomauditllc@gmail.com |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ....................4
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН....................7
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА....................13
3.1 Компани, түүний үйл ажиллагаа....................13
3.2 Компанийн гадаад, дотоод орчин....................13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал....................14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт......14
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл....................16
4. АУДИТЫН ТАЙЛАН....................18
4.1 Ерөнхий зүйл ....................18
4.2 Материаллаг байдал....................18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт....................18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал......18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ....................18
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд ....................18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт....................19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал....................20
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ....................21
5.1 Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа....................21
5.2 Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн санхүүгийн зөрчил....................21
5.2.1 Албан шаардлага ....................21
5.2.2 Зөвлөмж....................24
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ....................26

## Товчилсон үгийн жагсаалт

| **Товчилсон үг** | Тайлбар |
|---|---|
| **АДБОУС** | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| **МУЗГ** | Монгол Улсын Засгийн газар |
| **МУИХ** | Монгол Улсын Их Хурал |
| **НББОУС** | Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| **СТОУС** | Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт |
| **ТБОНӨ** | Төрийн болон орон нутгийн өмч |
| **ТӨХК** | Төрийн өмчит хувьцаат компани |
| **ТӨХХК** | Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани |
| **ТУЗ** | Төлөөлөн удирдах зөвлөл |
| **ТЭЗҮ** | Техник эдийн засгийн үндэслэл |
| **ХК** | Хувьцаат компани |
| **ХХК** | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.16 № 06/724

танай ____________-ны №____________-т

ХӨДӨӨ АЖ АХУЙН КОРПОРАЦИ
ТӨХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Б.ЦОГТСАРАН ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хөдөө аж ахуйн корпораци ТӨХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн нийт 141,651.3 сая төгрөгийн дараах зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давж, дангаараа буюу эсвэл нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Хөдөө аж ахуйн корпораци ТӨХХК-ийн Угтаал салбарын 2025 оны хөрөнгийн тооллогоор үүссэн 402.5 сая төгрөгийн 423.64 тонн хэмжээтэй будааны дутагдлыг шийдвэрлээгүй;
- Тус корпорацийн бараа материалын дансанд бүртгэлтэй 389.2 сая төгрөгийн үр тарианы ургамал хамгаалалын бодис, 551.9 сая төгрөгийн төмс хүнсний ногооны ургамал хамгааллын бодисыг хадгалах хугацаа дууссан, цаашид худалдан борлуулах боломжгүй болсон;
- Бүртгэлтэй хаяган дээрээ байхгүй 252 харилцагчийн 4,123.9 сая төгрөгийн, татан буугдсан 43 харилцагчийн 633.1 сая төгрөгийн, эзэн холбогдогч нь нас барсан 80 харилцагчийн 388.9 сая төгрөгийн авлагуудыг эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлээгүй;

- Шүүхийн шийдвэрээр эрх бүхий албан тушаалтны буруутай шийдвэрээр ажлаас чөлөөлөгдсөн 2 ажилтанд төлсөн 111.8 сая төгрөгийн нөхөн төлбөрийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлээгүй;
- Тайлант онд 3144 харилцагчаас авах 44,002.7 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй.

Эдгээр нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1, 73 дугаар зүйлийн 73.2, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6, Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1, 103.2 дахь заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Хүнсний хувьсгал болон Засгийн газраас хэрэгжүүлж буй "Атарын 4" аяныг хэрэгжүүлэх хүрээнд тариалангийн талбайн хөрсний үржил шимийг хамгаалах, сайжруулах, нэгж талбайгаас авах ургацыг нэмэгдүүлэх зорилгоор Ургамал хамгааллын бодис, бордооны дамжуулан борлуулалтыг тусгай зөвшөөрөлтэй нийт 33 аж ахуй нэгжтэй хамтран ажиллах гэрээ байгуулан, зуучлан борлуулах үйл ажиллагаа явуулсан. Нийт ургамал хамгааллын бодис, бордооны дамжуулан зээлээр 10,563.1 сая төгрөгийн худалдан борлуулалт хийж, үйл ажиллагааны шимтгэлээр 691.0 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн нь өмнөх оноос 10 дахин өссөн байна.

Мөн тариалан эрхлэгчдэд орчин үеийн техник нийлүүлэх чиг үүргийн хүрээнд нийт 12 техникийн диллер аж ахуй нэгжүүдтэй гэрээ байгуулж тоног төхөөрөмжийг дамжуулан зээлээр худалдан борлуулсан. Тайлант онд 5 аж ахуй нэгжийн 11 ширхэг 1,810.3 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг дамжуулан зээлээр худалдан борлуулж үйл ажиллагааны шимтгэлээр 57.1 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлжээ.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Засгийн газрын 2020 оны "Газар тариалангийн тогтвортой хөгжлийг дэмжих зарим арга хэмжээний тухай" 138 дугаар тогтоолын хэрэгжилтийн хүрээнд 2013 оны "Дамжуулан зээлийн гэрээ"-нд нэмэлт өөрчлөлт оруулж гэрээний дүнг төгрөгт шилжүүлж, хүүг жилийн 6.0 хувиар тогтоосон. Гадаад валютын ханшийн гарзыг бууруулах зорилгоор 2019 онд авсан дамжуулан зээлийн гэрээг мөн төгрөгт шилжүүлэх хүртэл нийт 76,167.4 сая төгрөгийн алдагдлыг шийдвэрлэхээр Сангийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хүсэлт хүргүүлсээр байгаа боловч шийдэгдээгүй байна.

**Бусад асуудал**

Бусад асуудал нь аудитын дүгнэлтэд шууд нөлөөлөхгүй боловч цаашид тайлангийн хэрэглэгчид зайлшгүй анхаарах шаардлагатай. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад асуудлыг хамраагүй болно.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд Аудитын олон улсын стандартын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

9006109
АТА16087
9025081411

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | БАЛАНСЫН ЗҮЙЛС | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **1** | **Хөрөнгө** | **-** | **-** |
| **1.1** | **Эргэлтийн хөрөнгө** | | |
| 1.1.1 | Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 892,209,987.47 | 2,021,793,041.89 |
| 1.1.2 | Дансны авлага | 177,921,471,533.92 | 193,969,730,166.76 |
| 1.1.3 | Татвар, НДШ-ийн авлага | - | 113,082.00 |
| 1.1.4 | Бусад авлага | 146,807,792.78 | 347,637,196.17 |
| 1.1.5 | Бусад санхүүгийн хөрөнгө | - | - |
| 1.1.6 | Бараа материал | 104,192,240,534.12 | 78,916,728,448.22 |
| 1.1.7 | Урьдчилж төлсөн зардал/тооцоо | - | - |
| 1.1.9 | Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) | - | - |
| **1.1.11** | **Эргэлтийн хөрөнгийн дүн** | **283,152,729,848.29** | **275,256,001,935.04** |
| **1.2** | **Эргэлтийн бус хөрөнгө** | | |
| 1.2.1 | Үндсэн хөрөнгө | 56,858,915,262.39 | 55,822,451,521.91 |
| 1.2.2 | Биет бус хөрөнгө | 22,402,909,623.46 | 22,791,085,873.49 |
| 1.2.3 | Биологийн хөрөнгө | - | - |
| 1.2.4 | Урт хугацаат хөрөнгө оруулалт | - | - |
| 1.2.5 | Хайгуул ба үнэлгээний хөрөнгө | - | - |
| 1.2.6 | Хойшлогдсон татварын хөрөнгө | - | - |
| 1.2.7 | Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө | - | - |
| 1.2.8 | Бусад эргэлтийн бус хөрөнгө | - | - |
| **1.2.10** | **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | **79,261,824,885.85** | **78,613,537,395.40** |
| **1.3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **362,414,554,734.14** | **353,869,539,330.44** |
| **2** | **ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ** | | |
| **2.1** | **ӨР ТӨЛБӨР** | | |
| **2.1.1** | **Богино хугацаат өр төлбөр** | | |
| 2.1.1.1 | Дансны өглөг | 75,727,241,846.42 | 50,952,591,524.64 |
| 2.1.1.2 | Цалингийн өглөг | 3,095,100.92 | 3,110,006.32 |
| 2.1.1.3 | Татварын өр | - | - |
| 2.1.1.4 | НДШ - ийн өр | 7,229,929.55 | 342,940.24 |
| 2.1.1.5 | Банкны богино хугацаат зээл | - | - |
| 2.1.1.6 | Хүүний өглөг | 22,078,862,991.98 | 25,443,096,141.98 |
| 2.1.1.7 | Ногдол ашгийн өглөг | - | - |
| 2.1.1.8 | Урьдчилж орсон орлого | 431,644,622.77 | 409,398,920.77 |
| 2.1.1.9 | Нөөц /өр төлбөр/ | - | - |
| 2.1.1.10 | Бусад богино хугацаат өр төлбөр | 440,334,571.90 | 384,895,471.90 |
| **2.1.1.12** | **Богино хугацаат өр төлбөрийн дүн** | **98,688,409,063.54** | **77,193,435,005.85** |
| **2.1.2** | **Урт хугацаат өр төлбөр** | | |
| 2.1.2.1 | Урт хугацаат зээл | 169,482,548,006.03 | 163,642,515,664.93 |
| 2.1.2.2 | Нөөц /өр төлбөр/ | - | - |
| 2.1.2.3 | Хойшлогдсон татварын өр | - | - |
| 2.1.2.4 | Бусад урт хугацаат өр төлбөр | - | - |
| **2.1.2.6** | **Урт хугацаат өр төлбөрийн дүн** | **169,482,548,006.03** | |

| | | | |
|---|---|---|---|
| | | | **163,642,515,664.93** |
| **2.2** | **ӨР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН** | **268,170,957,069.57** | **240,835,950,670.78** |
| **2.3** | **ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ** | | |
| 2.3.1 | - төрийн | 81,130,221,166.51 | 81,130,221,166.51 |
| 2.3.2 | - хувийн | - | - |
| 2.3.3 | - хувьцаат | - | - |
| 2.3.4 | Халаасны хувьцаа | - | - |
| 2.3.5 | Нэмж төлөгдсөн капитал | - | - |
| 2.3.6 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 13,162,475,821.95 | 13,162,475,821.95 |
| 2.3.7 | Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц | - | - |
| 2.3.8 | Эздийн өмчийн бусад хэсэг | - | - |
| 2.3.9 | Хуримтлагдсан ашиг | (22,143,046,759.80) | 224,340,858.88 |
| 2.3.10 | Хуримтлагдсан ашиг тайлант үеийн | 22,093,947,435.89 | 18,516,550,812.32 |
| **2.3.11** | **Эзэмшигчдийн өмчийн дүн** | **94,243,597,664.55** | **113,033,588,659.66** |
| **2.4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ДҮН** | **340,320,607,298.23** | **353,869,539,330.44** |

**2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан**

/төгрөгөөр/

| **Мөрийн дугаар** | **Үзүүлэлт** | **2024 оны 12-р сарын 31** | **2025 оны 12-р сарын 31** |
|---|---|---|---|
| 1 | Борлуулалтын орлого(цэвэр) | 50,502,061,764.06 | 91,563,644,474.25 |
| 2 | Борлуулсан бүтээгдэхүүний өртөг | 49,360,555,656.31 | 80,351,652,897.24 |
| **3** | **Нийт ашиг (алдагдал)** | **1,141,506,107.75** | **11,211,991,577.01** |
| 4 | Түрээсийн орлого | 3,640,650,101.52 | 2,399,176,055.74 |
| 5 | Хүүний орлого | 1,822,929,882.54 | 1,229,215,615.02 |
| 6 | Ногдол ашгийн орлого | - | - |
| 7 | Эрхийн шимтгэлийн орлого | - | - |
| 8 | Бусад орлого | 36,665,153,866.75 | 21,962,298,244.01 |
| 9 | Борлуулалт, маркетингийн зардал | 4,924,343,298.74 | 3,853,846,910.07 |
| 10 | Ерөнхий ба удирдлагын зардал | 10,027,980,828.07 | 9,085,816,321.64 |
| 11 | Санхүүгийн зардал | 3,951,162,348.33 | 3,401,907,370.69 |
| 12 | Бусад зардал | 2,043,833,708.37 | 959,206,157.62 |
| 13 | Гадаад валютын ханшийн зөрүүний олз, гарз | 227,992,239.47 | 985,353,919.44 |
| 14 | үндсэн хөрөнгө данснаас хассаны олз, гарз | 980,099.69 | - |
| 16 | Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз, гарз | - | - |
| 17 | Бусад ашиг (алдагдал) | - | - |
| **18** | **Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)** | **22,093,947,435.89** | **18,516,550,812.32** |
| 19 | Орлогын татварын зардал | - | - |
| **20** | **Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)** | **22,093,947,435.89** | **18,516,550,812.32** |
| 21 | Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал) | - | - |
| **22** | **Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)** | **22,093,947,435.89** | **18,516,550,812.32** |
| **23** | **Бусад дэлгэрэнгүй орлого** | **-** | **-** |
| 23.1 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү | - | - |
| 23.2 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - |
| 23.3 | Бусад олз (гарз) | - | - |
| **24** | **Нийт дэлгэрэнгүй орлогын дүн** | **-** | **-** |
| **25** | **Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)** | **-** | **-** |

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| № | Үзүүлэлт | Өмч | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **1** | **2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | **-** | **-** | **80,309,003.31** | **80,309,003.31** |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | - | - | - | - |
| 3 | Залруулсан үлдэгдэл | 81,130,221,166.51 | 13,162,475,821.95 | (22,143,046,759.80) | 72,149,650,228.66 |
| 4 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | - | - | 22,093,947,435.89 | 22,093,947,435.89 |
| 5 | Бусад дэлгэрэнгүй орлого | - | - | - | - |
| 6 | Өмчид гарсан өөрчлөлт | - | - | - | - |
| 7 | Зарласан ногдол ашиг | - | - | - | - |
| 8 | Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | - | - | - | - |
| **1** | **2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | **81,130,221,166.51** | **13,162,475,821.95** | **(49,099,323.91)** | **94,243,597,664.55** |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | - | - | 273,440,182.79 | 273,440,182.79 |
| 3 | Залруулсан үлдэгдэл | 81,130,221,166.51 | 13,162,475,821.95 | 224,340,858.88 | 94,517,037,847.34 |
| 4 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | - | - | 18,516,550,812.32 | 18,516,550,812.32 |
| 5 | Бусад дэлгэрэнгүй орлого | - | - | - | - |
| 6 | Өмчид гарсан өөрчлөлт | - | - | - | - |
| 7 | Зарласан ногдол ашиг | - | - | - | - |
| 8 | Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | - | - | - | - |
| **9** | **2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | **81,130,221,166.51** | **13,162,475,821.95** | **18,740,891,671.20** | **113,033,588,659.66** |

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **1** | **ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1.1** | **Мөнгөн орлогын дүн** | **70,527,884,853.94** | **90,215,462,400.76** |
| 1.1.1 | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого | 33,679,676,513.17 | 66,618,658,868.74 |
| 1.1.2 | Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого | - | - |
| 1.1.3 | Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө | - | - |
| 1.1.4 | Буцаан авсан албан татвар | - | - |
| 1.1.5 | Татаас, санхүүжилтийн орлого | - | - |
| 1.1.6 | Бусад мөнгөн орлого | 36,848,208,340.77 | 23,596,803,532.02 |
| **1.2** | **Мөнгөн зарлагын дүн** | **63,384,920,354.61** | **82,024,690,870.53** |
| 1.2.1 | Ажиллагчдад төлсөн | 3,862,301,285.84 | 3,341,831,568.98 |
| 1.2.2 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 1,075,007,362.87 | 1,008,045,569.04 |
| 1.2.3 | Бараа материал худалдан авахад төлсөн | 47,864,135,513.89 | 52,482,114,182.76 |
| 1.2.4 | Ашиглалтын зардалд төлсөн | 523,344,996.20 | 575,073,207.72 |
| 1.2.5 | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн | 456,576,958.00 | 114,098,692.40 |
| 1.2.6 | Хүүний төлбөрт төлсөн | 127,108.19 | 7,007,921.85 |
| 1.2.7 | Татварын байгууллагад төлсөн | 1,319,389,504.58 | 423,714,244.94 |
| 1.2.8 | Даатгалын төлбөрт төлсөн | 702,850.00 | 1,071,506.00 |
| 1.2.9 | Бусад мөнгөн зарлага | 8,283,334,775.04 | 24,071,733,976.84 |
| **1.3** | **Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **7,142,964,499.33** | **8,190,771,530.23** |
| **2** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **2.1** | **Мөнгөн орлогын дүн** | **126,518,895.17** | **112,844,159.66** |
| 2.1.1 | Үндсэн хөрөнгө борлуулсны орлого | - | - |
| 2.1.2 | Биет бус хөрөнгө борлуулсны орлого | - | - |
| 2.1.3 | Хөрөнгө оруулалт борлуулсны орлого | - | - |
| 2.1.4 | Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого | - | - |
| 2.1.5 | Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт | - | - |
| 2.1.6 | Хүлээн авсан хүүний орлого | 126,518,895.17 | 112,844,159.66 |
| 2.1.7 | Хүлээн авсан ногдол ашиг | | - |
| **2.2** | **Мөнгөн зарлагын дүн** | **1,471,170,048.00** | **193,250,660.00** |
| 2.2.1 | Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 1,471,170,048.00 | 193,250,660.00 |
| 2.2.2 | Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | - | - |
| 2.2.3 | Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн | - | - |
| 2.2.4 | Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | - | - |
| 2.2.5 | Бусдад олгосон зээл болон урьдчилгаа | - | - |
| **2.3** | **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **(1,344,651,152.83)** | **(80,406,500.34)** |
| **3** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **3.1** | **Мөнгөн орлогын дүн** | **-** | **-** |
| 3.1.1 | Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | - | - |

| | | | |
|---|---|---|---|
| 3.1.2 | Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | - | - |
| 3.1.3 | Төрөл бүрийн хандив | - | - |
| **3.2** | **Мөнгөн зарлагын дүн** | **7,643,599,145.36** | **6,982,384,374.14** |
| 3.2.1 | Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө | - | - |
| 3.2.2 | Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн | 7,643,599,145.36 | 6,982,384,374.14 |
| 3.2.3 | Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн | - | - |
| 3.2.4 | Төлсөн ногдол ашиг | - | - |
| **3.3** | **Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **(7,643,599,145.36)** | **6,982,384,374.14** |
| **3.4** | **Валютын ханшийн зөрүү** | **(124,529,454.13)** | **1,602,398.67** |
| **4** | **Бүх цэвэр мөнгөн гүйлгээ** | **(1,969,815,252.99)** | **1,129,583,054.42** |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **2,862,025,240.45** | **892,209,987.47** |
| **6** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **892,209,987.47** | **2,021,793,041.89** |

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

| № | Үзүүлэлт | Х/н | 2024 оны гүйцэтгэл | 2025 он | | Харьцуулалт | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | 2024 гүйц/ 2025 гүйц | Хувь | 2025 төл/ 2025 гүйцэт | Хувь |
| ***Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт гол нэр төрлөөр:*** | | | **57,667.20** | **30,000.00** | **38,795.29** | **(18,871.91)** | **640.27** | **8,795.29** | **129.32** |
| 1 | Хүнсний улаанбуудай | тонн | 49,528.50 | 23,000.00 | 29,597.63 | (19,930.87) | 59.76 | 6,597.63 | 128.69 |
| | Үрийн буудай | тонн | 7,756.20 | 5,000.00 | 7,339.15 | (417.05) | 94.62 | 2,339.15 | 146.78 |
| | Тэжээлийн буудай | тонн | 382.50 | 2,000.00 | 1,858.51 | 1,476.01 | 485.88 | (141.49) | 92.93 |
| 2 | **Нийт орлого** | **м.төг** | **56,603,298.7** | **67,562,581.2** | **95,652,501.4** | 39,049,202.7 | 169.0 | 28,089,920.2 | 141.6 |
| 3 | **Нийт зардал** | **м.төг** | **64,312,879.6** | **67,304,265.0** | **92,353,828.6** | 28,040,948.9 | 143.6 | 25,049,563.6 | 137.2 |
| | Үүнээс: Удирдлагын зардал | м.төг | 14,952,324.0 | 11,639,265.0 | 12,002,175.7 | (2,950,148.3) | 80.3 | 362,910.7 | 103.1 |
| 4 | **Татварын өмнөх ашиг** | **м.төг** | **(7,709,581.0)** | **258,316.2** | **3,298,672.8** | 11,008,253.8 | (42.8) | 3,040,356.6 | 1,277.0 |
| 5 | **Цэвэр ашиг /алдагдал/** | **м.төг** | **-** | **232,484.6** | **-** | - | | (232,484.6) | - |
| 6 | **Төсвийн төлбөрт нийт дүн** | **м.төг** | **1,510,868.7** | **1,498,902.3** | **1,518,091.6** | 7,222.9 | 100.5 | 19,189.3 | 101.3 |
| | в/ НДШ | м.төг | 1,082,449.4 | 1,072,602.3 | 1,008,045.6 | (74,403.8) | 93.1 | (64,556.8) | 94.0 |
| | г/ Хүн амын орлогын татвар | м.төг | 426,634.7 | 424,993.4 | 506,307.3 | 79,672.6 | 118.7 | 81,313.9 | 119.1 |
| | д/ Үл хөдлөх хөрөнгийн татвар | м.төг | - | - | - | - | | - | |
| | з/ Тээврийн хэрэгслийн татвар | м.төг | 1,784.6 | 1,306.6 | 3,738.8 | 1,954.2 | 209.5 | 2,432.2 | 286.1 |
| 7 | Төрийн өмчийн ногдол ашгийн өглөг | м.төг | | | | - | | - | |
| 8 | Нийт ажиллагсдын тоо | хүн | 123.0 | 121.0 | 121.0 | (2.0) | 98.4 | - | 100.0 |
| 9 | Нийт цалингийн сан | м.төг | 4,487,305.0 | 4,047,556.0 | 4,047,556.0 | (439,749.0) | 90.2 | - | 100.0 |
| 10 | Нэг ажиллагчийн дундаж цалин | м.төг | 3,040.2 | 2,787.6 | 2,787.6 | (252.6) | 91.7 | - | 100.0 |
| 11 | Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал | м.төг | 1.1 | 1.0 | 1.0 | (0.2) | 85.0 | (0.0) | 96.9 |
| 12 | Хөрөнгө оруулалт | м.төг | 2,432,385.8 | 3,296,065.2 | 2,470,475.7 | 38,089.9 | 101.6 | (825,589.5) | 75.0 |
| 13 | **Нийт авлага** | **м.төг** | **81,604,120.0** | **32,455,792.0** | **17,262,360.1** | **(64,341,759.9)** | **21.2** | **(15,193,432.0)** | **53.2** |
| | Үүнээс: Найдваргүй | м.төг | - | - | - | **-** | | - | |
| 14 | **Нийт өглөг** | **м.төг** | **8,008,121.8** | **32,455,792.0** | **14,587,256.0** | **6,579,134.2** | **182.2** | **(17,868,536.0)** | **44.9** |
| | Богино хугацаат өр төлбөр | м.төг | 3,444,404.1 | 15,800,335.0 | 7,734,871.6 | 4,290,467.5 | 224.6 | (8,065,463.4) | 49.0 |
| | Урт хугацаат өр төлбөр | м.төг | 4,563,717.7 | 16,655,457.1 | 6,852,384.4 | 2,288,666.7 | 150.1 | (9,803,072.7) | 41.1 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Компани, түүний үйл ажиллагаа

Хөдөө аж ахуйн корпораци ТӨХХК нь анх 1991 онд Сэлэнгэ аймгийн Сайхан суманд Үр тариа нөөц хадгалах компани нэрээр үүсгэн байгуулагдаж, 100 гаруй ажиллагсадтайгаар үйл ажиллагаагаа эхэлсэн бөгөөд Засгийн газрын 1999 оны 37 дугаар тогтоолоор “Буудай сан”, 2005 оны 139 дүгээр тогтоолоор “Тариалан эрхлэлтийг дэмжих сан”, 2020 оны 16 дугаар тогтоолоор Тариалан эрхлэлтийг дэмжих санг Мал хамгаалах сантай нэгтгэн “Хөдөө аж ахуйг дэмжих сан” болгон өөрчилсөн байна.

Засгийн газрын 2021 оны 394 дүгээр тогтоолоор төрөөс хөдөө аж ахуйн салбарт үзүүлэх дэмжлэгийг хүртээмжтэй, үр дүнтэй үзүүлэх, зах зээлийн бодит эрэлт, хэрэгцээнд тулгуурласан ашигт ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор "Хөдөө аж ахуйн корпораци" ТӨХХК-ийг байгуулж, дүрмийг баталжээ.

Тус компанийн үндсэн зорилтыг “Хөдөө аж ахуйн салбарыг дэмжих, дэмжлэгийн нэр төрөл, хүртээмжийг нэмэгдүүлэх, өрсөлдөх чадварыг хөгжүүлэх ажил, үйлчилгээг зохион байгуулахад оршино” гэж тодорхойлсон байна.

Компанийн дүрэмд  дараах үйл ажиллагааны чиглэлийг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Үүнд:

- Таримал ургамлын сорт сорих, үр үржүүлэх;
- Хүнсний болон үрийн улаанбуудай, тэжээлийн ургамлын үрийн нөөц бүрдүүлэх;
- Уламжлалт болон эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан, үрийн аж ахуйг дэмжин хөгжүүлэх;
- Хөдөө аж ахуйн зориулалттай трактор, комбайн, техник, тоног төхөөрөмж, хүлэмж, усалгааны багаж, хэрэгсэл, таримлын үр, суулгац, эрдэс болон органик бордоо, түлш, шатах тослох материал, ургамал хамгааллын бодисыг дотоодын үйлдвэрээс хангах, дотоодод үйлдвэрлэдэггүй бараа, материалыг импортоор нийлүүлэх, борлуулах;
- Мал аж ахуйн болон хадлан, тэжээл, судалгаа, шинжилгээ, лабораторийн техник, тоног төхөөрөмж, малын үржүүлгийн бүтээгдэхүүнийг нийлүүлэх, борлуулах;
- Хөдөө аж ахуйн салбарт олгох дэмжлэгийн нэр төрөл, хүртээмжийг нэмэгдүүлэх;
- Зах зээлийн бодит хэрэгцээнд тулгуурласан хөдөө аж ахуйн дэмжлэгийн бодлогыг харилцан үр ашигтай байхаар хэрэгжүүлэх;
- Үйл ажиллагааны борлуулалтын орлогоос болон авлага барагдуулах замаар хөрөнгө төвлөрүүлэх, хөрөнгө оруулалт хийх, хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх;
- Орлого нэмэгдүүлэхэд чиглэсэн хуулиар хориглоогүй бизнесийн үйл ажиллагаа явуулах;
- Үр ашигтай хөшүүргийн бодлого хэрэгжүүлэн авлага, барагдуулалтыг нэмэгдүүлэх, байгууллагын санхүүгийн чадавхыг дээшлүүлэх;
- Үйлдвэрлэлийн менежментийг сайжруулан элеватор, агуулахын ариутгал, халдваргүйжүүлэлт хийх, шаардлагатай засварууд, худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулж, улаанбуудай, малын тэжээлийн хадгалалтын нөхцөлийг сайжруулах;
- Дэд бүтцийн эд хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах;
- Хөрөнгийн ашиглалтыг сайжруулах, хөрөнгийн өгөөжийг нэмэгдүүлэх;
- Хөдөө аж ахуйн техникийн болон элеватор, агуулахын түрээсийн үйлчилгээг хөгжүүлэх;
- Инноваци, шинэ технологи нэвтрүүлэх;
- Зөвлөх үйлчилгээ үзүүлэх.

Компани нь 100.0 хувь төрийн өмчит бөгөөд нэг хувьцаа эзэмшигчтэй байна. Хувьцаа эзэмшигчийн эрхийг Засгийн газрын эрх олгосоноор Хөдөө, аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага байна гэж тодорхойлсон байна.

### 3.2 Компанийн гадаад, дотоод орчин

Хөдөө аж ахуйн корпораци ТӨХХК нь Компаний тухай хууль, Иргэний тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Инновацийн тухай хууль, Тариалангийн тухай хууль,

Ургамал хамгааллын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Газрын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон холбогдох МУИХ, МУЗГ-ын тогтоол, компанийн удирдлагаас баталсан дүрэм, журмуудыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Тайлант хугацаанд компанийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль;
- Зөрчлийн тухай хууль;
- Компанийн ТУЗ-ийн 2025 оны 17 дугаар тогтоолоор “Компанийн активын эрсдэлийн сангийн журам”, “Авлага барагдуулах журам”-ыг баталсан;
- Хөдөө аж ахуйн корпораци ТӨХХК-ийн гүйцэтгэх захирлын 2025 оны А/09 дүгээр тушаалаар Хөдөлмөрийн дотоод журмыг баталсан.

Компанийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд улаанбуудайны хадгалалт, бүртгэл, тооцоонд тавих хяналт сул байгааг үндэслэн дотоод хяналтын үр нөлөөг сайжруулах шаардлагатай асуудлууд байна гэж үзсэн.

Дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн тайлант онд нийт 13 ажил хэрэгжүүлэхээр төлөвлөгөө батлуулж, хэрэгжилтийг 90.0 хувьтай хэрэгжсэн гэж тайлагнасан байна. Дараах ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Тухайлбал:

- Төлөвлөгөөт 4 хяналт шалгалт;
- Төлөвлөгөөт бус 3 хяналт шалгалт;
- Аудитын тайлангийн зөвлөмж, албан шаардлагын хүрээнд шалгалт явуулсан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөдөө аж ахуйн корпораци ТӨХХК-ийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Компанийн санхүүгийн үйл ажиллагаанд гүйцэтгэх захирлын 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн А/142 дугаар тушаалаар баталгаажуулсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Хөдөө аж ахуйн корпораци ТӨХХК нь 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө, өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн өмнөх оноос 8,545.0 сая төгрөгөөр буюу 2.4 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 892,210.0 | 2,021,793.0 | 1,129,583.0 |
| Авлага | 178,068,279.3 | 194,317,480.5 | 16,249,201.2 |
| Бараа материал | 5,123,188.3 | 4,994,135.6 | (129,052.7) |

| | | | |
|---|---|---|---|
| Нөөцийн бараа | 99,069,052.3 | 73,922,592.9 | (25,146,459.4) |
| Эргэлтийн бус хөрөнгө | 79,261,824.9 | 78,613,537.4 | (648,287.5) |
| **Нийт хөрөнгө** | **362,414,554.8** | **353,869,539.4** | **(8,545,015.4)** |
| Богино хугацаат өр төлбөр | 98,688,409.1 | 77,193,435.0 | (21,494,974.1) |
| Урт хугацаат өр төлбөр | 169,482,548.0 | 163,642,515.7 | (5,840,032.3) |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 94,243,597.7 | 113,033,588.7 | 18,789,991.0 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **362,414,554.8** | **353,869,539.4** | **(8,545,015.4)** |

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 2,021.8 сая төгрөг болж, өмнөх оноос 1,129.6 сая төгрөгөөр нэмэгдсэн нь хүнсний тариаланчдад улаанбуудайн төлбөрийг тайлант хугацаанд төлөөгүйгээс шалтгаалсан байна. Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 2,015.9 сая төгрөг нь арилжааны банк дахь 16 харилцах дансанд, 5.9 сая төгрөгийн валютын 2 харилцах дансны үлдэгдэл байна.

Авлагын дансны үлдэгдэл 194,317.5 сая төгрөг болж, өмнөх оноос 16,249.2 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд зарим тариалангийн бүс нутагт ургацын гарц бага байсан, мөн хүнсний улаанбуудайн урамшуулал тайлант хугацаанд олгоогүй зэрэг нь голлон нөлөөлсөн байна.

Авлагын  дансанд дараах төсөл арга хэмжээний үлдэгдэл тайлагнасан байна. Үүнд:

- БНХАУ-ын ЗГ-ын хөнгөлөлттэй зээлийн 49,733.2 сая төгрөг,
- БНБУ-ын ЗГ-ын хөнгөлөлттэй зээлийн 4,406.7 сая төгрөг,
- Ди Би Эм Лизинг ХХК-тай байгуулсан санхүүгийн түрээсийн зээлийн 811.6 сая төгрөг,
- Мал хамгаалах сангаас олгосон зээлийн 16,267.8 сая төгрөг,
- Япон улсын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжсэн КР 1, 2 төслийн зээлийн 3,965.5 сая төгрөг,
- Техник дундын үйлчилгээний төвүүдийн 2,050.3 сая төгрөг,
- Гурилын үйлдвэрүүдээс авах 34,547.5 сая төгрөг,
- Үрийн болон тэжээлийн улаанбуудайн 23,441.3 сая төгрөг,
- Жимсний суулгац, хүлэмж, хүнсний ногооны тоног төхөөрөмжийн 13,691.6 сая төгрөг,
- 2012 оноос олгосон дэмжлэгийн 13,947.2 сая төгрөг,
- Шатахуун, хор, бордооны дэмжлэгийн 7,011.7 сая төгрөг,
- Бусад 24,443.0 сая төгрөгийн авлага тус тус бүртгэлтэй байна.

Нөөцийн барааны үлдэгдэл 73,922.6 сая төгрөг болж, өмнөх оноос 25,146.5 сая төгрөгөөр буурсан нь ургацын гарц муу байсантай холбоотой гурил үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүдийн худалдан авалт нэмэгдэж, борлуулалт нэмэгдэж нөөцийн бараа буурснаас шалтгаалсан байна.

Нөөцийн үлдэгдэлд хүнсний улаанбуудайн 44,512.2 сая төгрөгийн 35,338.9 тн, үрийн 14,724.4 сая төгрөгийн 4,496.2 тн, тэжээлийн буудайн 1,633.9 сая төгрөгийн 1,856.7 тн нөөц, дамжуулан зээлийн болон өөрийн эх үүсвэрээр БНХАУ, ОХУ, БНБУ, Польш зэрэг улсаас нийлүүлсэн ХАА-н 9,109.4 сая төгрөгийн техник төхөөрөмж бүртгэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны цэвэр үлдэгдэл 79,261.8 сая төгрөг болж, өмнөх оноос 648.3 сая төгрөгөөр буурсан байна. Энэ нь өөрийн эх үүсвэрээр 1,814.6 сая төгрөгийн хөрөнгө худалдан авч, ТӨБЗГ-ын 2024 оны 205 дугаар тогтоолоор 550.4 сая төгрөгийн дансны үнэтэй машин тоног, төхөөрөмж, тавилга эд хогшил акталж данснаас хассан, тайлант жилийн хуримтлагдсан элэгдэл 2,652.7 сая төгрөгөөр буурсан зэргээс шалтгаалжээ.

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэл 77,193.4 сая төгрөг болж, өмнөх оноос 21,495.0 сая төгрөгөөр буурсан нь Ди би эм лизинг ХХК-ийн 7,149.7 сая төгрөг болон бусад харилцагчийн өрийг барагдуулсанаас шалтгаалсан байна.

Тайлант онд намрын ургацаас худалдан авсан Хүнсний улаанбуудай 9,749.1 сая төгрөг, Үрийн буудайн  6,233.1 сая төгрөг, 2025 онд Хамтран ажиллах гэрээний төлөлт 6,438.1 сая төгрөг, Улаанбаатар гурил ХХК-д төлөх 1,886.1 сая төгрөгийн өр төлбөр байна.

Өр төлбөр дансны 268,171.0 сая төгрөгийн үлдэгдлийн 36.8 хувь буюу 98,688.4 сая төгрөгийг богино хугацаат өр төлбөр, 63.2 хувь буюу 169,482.5 сая төгрөгийг урт хугацаат зээлийн өр төлбөр байна.

Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэл 163,642.5 сая төгрөг болж, өмнөх оноос 5,840.0 сая төгрөгөөр буурсан нь БНБУ-ын зээлийн эргэн төлөлтөд 3,198.8 сая төгрөг, БНХАУ-ын зээлийн эргэн төлөлтөд 3,653.4 сая төгрөгийг төлсөнтэй холбоотой байна.

Урт хугацаат өр төлбөрт БНХАУ-ын ЗГ-ын хөнгөлөлттэй дамжуулан зээлийн 159,859.4 сая төгрөг, БНБУ-ын техникийн зээлийн 3,783.1 сая төгрөгийн өр төлбөр бүртгэлтэй байна. Үүнээс 54,427.5 хугацаандаа, 109,215.0 сая төгрөг хугацаа хэтэрсэн байна.

БНХАУ-ын ЗГ-ын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд байгуулсан дамжуулан зээлийн гэрээний төлбөрт 3,653.5 сая төгрөгийн эргэн төлөлт хийж 159,859.4 сая төгрөгийн үндсэн зээлийн үлдэгдэлтэй, үүнээс 109,215.0 сая төгрөгийн зээлийн хугацаа хэтэрсэн байна.

БНБУ-ын Засгийн газар, Монгол Улсын Засгийн газрын хоорондын экспортын зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд “Трактор, хөдөө аж ахуйн машин, агуулах нийлүүлэх” төслийн хүрээнд 2021 онд БНБУ-ын Хөгжлийн банкны зээлийг Сангийн Яам, ХХААХҮЯ-дын хооронд байгуулсан 3.8 сая еврогийн дамжуулан зээлийн гэрээний 1.7 сая евро буюу 5,969.7 сая төгрөгийн эхний үлдэгдэлээс тайлант онд хүүгийн төлбөрт 37.6 сая төгрөг, үндсэн зээлийн төлбөрт 3,263.3 сая төгрөгийн график төлөлт хийж, ханшийн зөрүүний 974.7 сая төгрөгийг нэмж бүртгэсэн байна. Тайлант оны жилийн эцсийн байдлаар хугацаандаа 3,783.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Засгийн газрын хувь оролцоо/Эздийн өмч дансны үлдэгдэл 113,033.6 сая төгрөг болж өмнөх оноос 18,790.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд 18,516.6 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтөд 273.4 сая төгрөгийн алдааны залруулга хийсэн нь нөлөөлсөн байна.

### 3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3[1]-т заасны дагуу компани нь санхүүгийн төлөвлөгөө, техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Хөдөө аж ахуйн корпораци ТӨХХК -ийн ТУЗ-ын 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталж, тайлант онд 2025 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 10 дугаар тогтоолоор 1 удаа тодотгосон байна

*Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт /гол нэр төрлөөр/*

Хүн амын гурилын эрэлт, хангамжийг тогтвортой байлгах зорилгоор 23.0 мян.тн хүнсний улаан буудай, 5.0 мян.тн үрийн буудай, 2.0 мян.тн тэжээлийн буудай, нийт 30.0 мян.тн дотоодод ургуулсан, стандартын шаардлага хангасан хүсний буудай нөөцлөхөөр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр нийт 38.8 мян.тн буюу төлөвлөснөөс 29.3 хувиар илүү хэмжээний буудай нөөцөлснөөс хүнсний улаан буудай 29.6 мян.тн, үрийн буудай 7.3 мян.тн, тэжээлийн буудай 1.9 мян.тн байна.

*Батлагдсан төсвийн гүйцэтгэл*

Тайлант онд нийт 67,562.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 67,304.3 сая төгрөгийн зардал гаргаж, 232.5 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, төсөвт 1,498.9 сая төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 95,652.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 92,353.8 сая төгрөгийн зардал гарган, 3,298.7 сая төгрөгийн ашигтай ажиллаж, төсөвт 1,518.1 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Борлуулалтын орлого төлөвлөснөөс 28,089.9 сая төгрөгөөр буюу 41.6 хувиар давж биелсэн нь дараах шалтгаантай байна. Тухайлбал:

- Тайлант онд ургац бага гарсантай холбоотойгоор хүнсний улаанбуудайн борлуулалтын хэмжээ төлөвлөснөөс 2 дахин нэмэгдэж, орлого 26,738.5 сая төгрөгөөр давсан;
- Борлуулсан буудайн ачилт, боловсруулалтын туслах үйл ажиллагааны үйлчилгээний хөлс нь улаанбуудайн борлуулалт нэмэгдсэнтэй холбоотойгоор өссөн.

[1] 20.1.Захирал дараахь эрх, үүрэгтэй:3/үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах;

Нийт зардлын гүйцэтгэл төлөвлөснөөс 25,049.6 сая төгрөгөөр буюу 3.1 хувиар хэтэрсэн нь хүнсний улаанбуудайн борлуулалтын өсөлттэй холбоотойгоор борлуулсан барааны өртөг төлөвлөснөөс 24,686.7 сая төгрөгөөр илүү гүйцэтгэлтэй байсан нь голлон нөлөөлжээ.

*Хөрөнгө оруулалт*

Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд нийт 11 төсөл арга хэмжээнд 3,326.1 сая төгрөгийн төсөв батлаcнаас, гүйцэтгэлээр 9 арга хэмжээнд 2,493.7 сая төгрөгийг зарцуулсан байна. Үүнд:

- ХХААХҮЯ-ны харьяа байгууллагын шилжин суурьшиж байрлахад 2,013.5 сая төгрөг;
- Төмөр замын их засвар /дэр мод солих/ ажилд 195.2 сая төгрөг;
- Дээд галерейн засварт 123.4 сая төгрөг;
- Компьютер техник хэрэгсэл худалдан авахад 108.1 сая төгрөг;
- Сэлбэгийн нөөц байгуулах, бусад засварын ажил зэрэгт 53.5 сая төгрөг.

**Судалгааны үр дүн:** Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу дараах судалгааг авч, үр дүнг дүгнэлээ. Үүнд:

- Гүйцэтгэх захирлын 2025 оны А/09 дүгээр тушаалаар ажлын унаа, хоолны тарифыг 8.0-10.0 мянган төгрөгөөр тогтоож, тайлант хугацаанд 219.4 сая төгрөгийн хоол, унааны хөнгөлөлт олгосон.
- Тайлант онд  гадаад албан томилолтод 60.7 сая төгрөгийг түншийн харилцаа тогтоох, төслийн санхүүжилт судлахад зарцуулсан байна.
- Удирдлагын буруу шийдвэрээр ажлаас халагдсан 2 ажилтанд шүүхийн шийдвэрийн дагуу ажилгүй байсан хугацааны цалин, нийгмийн даатгалыг тооцож 111.8 сая төгрөгийн нөхөн төлбөрийг 2024 онд байгууллагаас барагдуулсаныг авлагаар тусгасан байна.
- Тухайн жилийн сургалтын төлөвлөгөөнд 20.8 сая төгрөг төлөвлөснөөс, гүйцэтгэлээр хувь хүний хөгжлийн, вагон төхөөрөмж чирэх оператор, ХАБЭА сургалт, мэргэжил дээшлүүлэх болон ажлын байрны шаардлагатай бусад сургалтуудад 14.0 сая төгрөг зарцуулж, 6.8 сая төгрөг хэмнэсэн байна.
- Тайлант онд 123 орон тоо батлагдсанаас гүйцэтгэлээр 121 орон тоогоор ажиллаж 2 орон тоо хэмнэсэн байна..
- Тус компани нь хэвлэл мэдээллийн 5 байгууллагатай 5.5 сая төгрөгийн гэрээ байгуулан ажилласан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хөдөө аж ахуйн корпораци ТӨХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн компани, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Пийк Ом Аудит” ХХК-ийн ахлах аудитор А.Мөнхцэцэг, аудитор Б.Наранчимэг нар гүйцэтгэж, захирал Б.Жаргалсайхан анхан шатны чанарын хяналтыг, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор П.Батцэцэг, аудитын менежер Э.Энхбаатар, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Хөдөө аж ахуйн корпораци ТӨХХК нь 2025 оны санхүүгийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2026 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 01/143 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл Их гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 70,536.8 сая төгрөгөөс 1 хувиар буюу 705.4 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд, албан томилолтоор онгоцоор явахад энгийн ангиллаар зорчих, компанийн зардлаар бэлэг дурсгалын зүйл бэлдэхгүй байх, ерөнхий гэрээний дагуу цахим дэлгүүрээс худалдан авалтыг гүйцэтгэх зэргээр хуульд заасан арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 412.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд нийт 167 мэдээллийг мэдээллийг хугацаанд нь, бүрэн байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн Шилэн дансны тухай хууль, тогтоомжтой нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

**1. Тушаал шийдвэртэй холбоотой**

Гүйцэтгэх захирлын 2023 оны А/107 дугаар "ХААДэмжих санд 2022 онд Солонгос улсаас тусламжаар нийлүүлсэн хүнсний ногооны үрийг хүлээж авсантай холбоотой гарсан зардал

бүрэн төлөгдөж дууссан тул аймаг, Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын захиалгыг үндэслэн үнэ төлбөргүй шилжүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх" тушаалыг Сэлэнгэ салбар нь 2023, 2024 онуудад хэрэгжүүлээгүй, 2025 оны үнэ төлбөргүй гарсан зардалд тайлагнасан байна.

Энэ нь Гүйцэтгэх захирлын А/32 дугаартай тушаалаар баталсан Хөдөө аж ахуйн корпораци ТӨХХК-ийн "Ёс зүйн дүрэм"-ийн 29 дүгээр зүйлд "*Удирдах, удирдуулах зарчмыг баримталж, удирдах дээд шатны байгууллага, албан тушаалтнаас баталсан шийдвэр, хууль ёсны үүрэг даалгавар, шаадлагыг цаг тухайд нь мэргэжлийн түвшинд хэрэгжүүлэх",* Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д *"Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална",* 5.1.3-т *"Жинхэнэ хэрэгжилтийн",* 5.1.4-т *"Үнэн зөв байх",* 10 дугаар зүйлийн 10.1-д *"Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлангийн жил тухайн оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлж, 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болно"* гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь*: Тушаал шийдвэрт тавих хяналтыг сайжруулж хавсралт, гүйцэтгэлийг тооцож байх зөвлөмж өглөө.

**2. Худалдан авах ажиллагаатай холбоотой**

Тайлант онд намрын буудайн хатаалгын 412.1 сая төгрөгийн шатахуун нийлүүлэгчийг сонгохдоо тендерийн баримт бичигт заасан "Бүтээгдэхүүн нийлүүлэлтийн хуваарь"-ийг ирүүлээгүй оролцогч байгууллагыг шалгаруулсан.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 26.9-д *"Тендер шалгаруулалтын баримт бичгийн бүх шаардлагыг нэгэн зэрэг хангасан тендерийг шаардлагад нийцсэн тендер гэж үзнэ"* гэж заасантай нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь*: Тендер шалгаруулалтын баримт бичгийн бүх шаардлагыг хангасан оролцогчийг гүйцэтгэгчээр шалгаруулж байх зөвлөмж өглөө.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, аудитын горим, сорилыг хэрэгжүүлсэн.

Аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажуулан, жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар үнэлж, залруулагдаагүй алдаа, зөрчлийг арилгуулахаар аудитын тайланд тусгасан.

Завсрын аудитаар нийт нийт 6,604.3 сая төгрөгийн 8 алдаа, зөрчил илэрснээс 83.3 сая төгрөгийн 2 алдааг залруулж, бусад асуудалд нотлох баримтыг үндэслэн жилийн эцсийн тайланд үнэлж, аудитын тайланд тусгалаа.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 128,274.4 сая төгрөгийн 33 зөрчилд, 116,681.4 сая төгрөгийн 16 албан шаардлага, 11,393.0 сая төгрөгийн 17 зөвлөмж өгснийг нотлох баримтад үндэслэн хянаж үнэлэхэд 66.7 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 2. Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт */мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Албан шаардлага | 16 | 116,681,449.3 | 9 | 24,927,909.9 | 56.3 |
| Зөвлөмж | 17 | 11,392,965.7 | 14 | 3,128,944.3 | 82.4 |
| **Нийт дүн** | **33** | **128,274,415.0** | **22** | **28,056,854.2** | **66.7** |

Дараах шийдвэрүүдийг хэрэгжүүлээгүй, хэрэгжилт хангалтгүй байна. Үүнд:

- Борлуулалтын гэрээний төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлүүлээгүй зөрчлийг таслан зогсоож, авлагыг бүрэн цуглуулж компанийг хохиролгүй болгох арга хэмжээ авах;
- Дамжуулан зээлийн гэрээний үүргийг зөрчиж, хугацаа хэтэрсэн өр төлбөрийг барагдуулах;
- Дамжуулан зээлийн төлбөрийн гэрээнд заасан хуваарьт хугацаанд төлөх;
- Санхүүгийн түрээсийн гэрээний үүргийг зөрчиж, хугацаа хэтэрсэн өр төлбөрийг барагдуулах;
- Түрээслэгчидтэй бүрэн тооцоо нийлж, тоног төхөөрөмжийг буцааж хүлээн авах;
- Компанийн хөрөнгө дутагдсан шалтгаан нөхцөлийг бүрэн тогтоох;
- Байгууллагын эзэмшилд бүртгэлтэй газрын эзэмших эрхийг байгууллагын нэр дээр бүртгүүлж, гэрчилгээг гаргуулах;
- Компанийн тайлант оны үрийн болон тэжээлийн улаанбуудайн борлуулалтын гэрээний үүргийн хэрэгжилт хангалтгүйгээс үрийн улаанбуудайн 3.8 тэрбум төгрөг, тэжээлийн улаанбуудайн 4.0 тэрбум төгрөгийн төлбөр гүйцэтгэгдээгүй, авлагын үлдэгдэлтэй байна. Үрийн улаанбуудайн зээлийн эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн 3.8 тэрбум төгрөгийн авлагаас 2.5 тэрбум төгрөгийн төлөлт хийлгэж 1.3 тэрбум төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.
- Элеваторуудын дулаан мэдрэгч, жингийн хэмжигч зэрэг нь ажиллахаа больсон нь хадгалалтын үеийн үзүүлэлтүүдэд тавих хяналт сулрах, чанар байдалд сөргөөр нөлөөлж буй эсэхийг Мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулж засвар үйлчилгээ хийхээр төлөвлөж ажиллах.

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах асуудлуудыг авч үзэн, нарийвчилсан горим, сорил хэрэгжүүлж, шийдвэр гаргах эрх бүхий байгууллагуудад хандах нь зүйтэй байна. Үүнд:

- Дамжуулан зээлийн гэрээ Сангийн яам болон Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам хооронд байгуулсан 2013.04.14 №7 гэрээгээр 40.0 сая ам.доллар 16 жилийн хугацаатай 2.0 хувийн хүүтэйгээр 2 багц техник нийлүүлсэн байдаг. Энэ техник нь 2012 онд БНХАУ-аас нийт 27.9 сая ам.долларын үнэ бүхий 3,150 ширхэг бага оврын трактор, хадуур тармуурын иж бүрдэлийн хамт, 5,250 ширхэг бага оврын трактор, анжисын хамт нийт 8,400 ширхэг нийлүүлэгдсэн. Тухайн үеийн ханшаар хөрвүүлэн төгрөгөөр харилцагч нарт зээл олгосонтой холбоотой 43,709.5 сая төгрөгийн гадаад вальютын ханшийн зөрүүний гарз үүссэн;
- Засгийн газрын 2020 оны 138 дугаар тогтоолоор хөдөө аж ахуйн техник тоног төхөөрөмжийн үнийг 50 хувь хөнгөлснөөс 27,508.9 сая төгрөгийн алдагдал хүлээсэн;
- Засгийн газрын 2017 оны 205 дугаар тогтоолоор Онцгой байдлын ерөнхий газарт 4,949.0 сая төгрөгийн техник, тоног төхөөрөмж шилжүүлсэн;
- Засгийн газрын 2020 оны “Газар тариалангийн тогтвортой хөгжлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” 138 дугаар тогтоолын хэрэгжилтийн хүрээнд 2013 оны “Дамжуулан зээлийн гэрээ”-нд нэмэлт өөрчлөлт оруулж гэрээний дүнг төгрөгт шилжүүлж, хүүг жилийн 6.0 хувиар тогтоосон. Гадаад валютын ханшийн гарзыг бууруулах зорилгоор 2019 онд авсан дамжуулан зээлийн гэрээг мөн төгрөгт шилжүүлэх хүртэл нийт 76,167.4 сая төгрөгийн алдагдлыг шийдвэрлэхээр Сангийн яам, ХХААХҮЯ-д хүсэлт хүргүүлсээр байгаа боловч шийдэгдээгүй;
- БНХАУ-ын зээлийн үлдэгдэл нь 2025 оны жилийн эцсийн байдлаар 159,859.4 сая төгрөг ба хугацаа хэтэрсэн 109,215.0 сая хугацаандаа 50,644.4 сая төгрөг байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

### 5.1 Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа

Аудитаар нийт 6,300.9 сая төгрөгийн 8 алдаа[2] илэрснийг аудитын явцад бүрэн залруулаа.

*Залруулсан алдаа:*

1) Бараа материалын дансанд бүртгэлтэй Хөтөл 2,565 тонн, Угтаал 2,300 тонн, нийт 4,865 тонн, 2,965.4 сая төгрөгийн улаанбуудайг 2026 онд борлуулахаар тохирсон хэрэгжээгүй борлуулалтын ББӨртгийг бүртгэж бараа материалын дансны үлдэгдлийг бодит бусаар бууруулан тайлагнасан;
2) Санхүүгийн программын автомат үйлдлийг хянаагүйгээс харилцагчийн дансны үлдэгдэлд бодит бус 382.4 сая төгрөгийн алданги тооцсон.
3) Улаанбаатар гурил ХХК-д улаанбуудайгаар төлөх өглөгийн үлдэгдлийг 2,965.4 сая төгрөгөөр дутуу илэрхийлсэн;
4) Шүүхийн шийдвэрийн дагуу эрх бүхий албан тушаалтны буруугаас чөлөөлөгдсөн 2 ажилтанд олгосон 111.8 сая төгрөгийн нөхөн төлбөрийг байгууллагын зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн;
5) Тайлант хугацаанд тооцсон үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг 0.3 сая төгрөгөөр дутуу тооцсон;
6) Хөдөө аж ахуйн таримал сорт сорих ажил гүйцэтгэх гэрээт ажлын зардал болон харилцагчид төлөх дансны өглөгийг 71.4 сая төгрөгөөр тус тус илүү илэрхийлсэн;
7) Удирдлагын шатахуун, салбаруудын сэлбэг материалын зэрэг 202.3 сая төгрөгийн зардлыг бусад зардлаар илэрхийлсэн;
8) Аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж өмнөх онд худалдан авсан 419.7 сая төгрөгийн биет бус хөрөнгийг 2024 оны зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэснийг залруулахдаа 2025 оны тайлант үеийн үр дүнг бууруулсан

зэрэг нь УСНББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга 1.27-д “Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой” гэж заасан болон санхүүгийн тайлагналын “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### 5.2 Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн санхүүгийн зөрчил

Аудитаар нийт 141,651.3 сая төгрөгийн 13 зөрчил[3] илэрсэнд 141,350.4 сая төгрөгийн зөрчилд 8 албан шаардлага хүргүүлж, 300.9 сая төгрөгийн зөрчилд 5 зөвлөмж өглөө.

Аудитаар илэрсэн 141,651.3 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 705.4 сая төгрөгөөс давсан тул зөрчлийн дүн болон шинж чанарын хувьд материаллаг гэж үзэн “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

#### 5.2.1 Албан шаардлага

*1. Илрүүлэлт:* Хөдөө аж ахуйн корпораци ТӨХХК-ийн Угтаал салбарын 2025 оны хөрөнгийн тооллогоор үүссэн 402.5 төгрөгийн 423.64 тонн хэмжээтэй будааны дутагдлыг шийдвэрлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.2-т *"Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана"* гэж заасныг зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь:* Тооллогоор үүссэн дутагдлыг шийдвэрлээгүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

[2] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үгнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[3] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

<u>*2. Илрүүлэлт:*</u> Тус байгууллагын бараа материалын дансанд бүртгэлтэй үр тарианы ургамал хамгаалалын бодис 12,042.9 литр 389.2 сая төгрөгийн, төмс хүнсний ногооны ургамал хамгааллын бодис 8.239.5 литр 551.9 сая төгрөгийн хөрөнгийн ашиглалтын хугацаа дууссан цаашид худалдан борлуулах боломжгүй болсон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д *"Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д *“Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”*, 20 дугаар зүйлийн 20.2.6-д *“Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”*, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-д *"Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна"* гэж заасныг тус тус зөрчсөн байна.

<u>*Шийдвэрлэсэн нь:*</u> Бараа материалын худалдан авалтыг оновчтой төлөвлөөгүй, ашиглалтын хугацаанд хяналт тавиагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

<u>*3. Илрүүлэлт:*</u> Бүртгэлтэй хаяган дээрээ байхгүй 252 харилцагчийн 4,123.9 сая төгрөгийн, татан буугдсан 43 харилцагчийн 633.1 сая төгрөгийн, эзэн холбогдогч нь нас барсан 80 харилцагчийн 388.9 сая төгрөгийн авлагуудыг ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д *"Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах"* гэж заасныг тус тус зөрчсөн байна.

<u>*Шийдвэрлэсэн нь:*</u> Барагдуулаагүй авлагуудыг ТУЗ-д хандан шийдвэрлүүлээгүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

<u>*4. Илрүүлэлт:*</u> Шүүхийн шийдвэрээр эрх бүхий албан тушаалтны буруутай шийдвэрээр ажлаас чөлөөлөгдсөн 2 ажилтанд төлсөн 111.8 сая төгрөгийн нөхөн төлбөрийг буруутай албан тушаалтанаар төлүүлээгүй байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-т *"Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ"*, 103.2-т *"Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай этгээдээр хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна"* гэж заасныг зөрчсөн байна.

<u>*Шийдвэрлэсэн нь:*</u> Албан тушаалтны буруутай шийдвэрийн улмаас байгууллагад учирсан хохирлыг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх арга хэмжээ аваагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

<u>*5. Илрүүлэлт:*</u> Тус байгууллагаас Орон сууцны урьдчилгаанд 2012 онд 4 ажилтанд өгсөн 80.0 сая төгрөг, 2025 онд Хөдөө аж ахуйн яамны ажлаас чөлөөлөгдсөн 1 ажилтантай холбоотой орон сууцны зээлийн урьдчилгаа төлбөрт төлсөн 76.8 сая төгрөгийн авлагыг барагдуулах талаар арга хэмжээ аваагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д *"Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах"*, 20.2.6-д *“Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”* гэж заасныг зөрчсөн байна.

*<u>Шийдвэрлэсэн нь:</u>* Авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

*<u>6. Илрүүлэлт:</u>* Тайлант онд 3144 харилцагчдаас авах 44,002.7 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д *“Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”*, 20 дугаар зүйлийн 20.2.5-д *“Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”*, 20.2.6-д *“Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”* гэж тус тус заасныг зөрчсөн байна.

*<u>Шийдвэрлэсэн нь:</u>* Авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

*<u>7. Илрүүлэлт:</u>* Өмнөх оны аудитаар өгсөн дараах албан шаардлагуудыг бүрэн хэрэгжүүлээгүй байна. Үүнд:

1) “Б” ХХК-тай 2024 онд байгуулсан улаанбуудайг худалдах АҮ/65, АҮ/102 дугаартай гэрээнүүдийн 7,273.3 сая төгрөгийн төлбөрийг барагдуулах тухай Дархан-Уул аймгийн сум дундын анхан шатны шүүхийн шүүгчийн 2025 оны 307/ШШ2025/02348 дугаартай "Зохигчийн эвлэрлийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгох тухай" захирамжаар “Хөдөө аж ахуйн корпораци” ТӨХХК нь 3,641.4 сая төгрөгийн алдангиас татгалзаж эвлэрсэн боловч, "Б" ХХК нь 2025 оны 11 сарын 17-ны өдрийн төлбөрийг төлсөн боловч 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдөр 200.0 сая төгрөг төгрөгийн төлбөрийг захирамжийн хуваарийн дагуу төлөөгүй;
2) Сангийн яам, ХХААХҮЯ хооронд 2013 онд анхлан байгуулж 2020 онд шинэчилсэн "Хөдөө аж ахуйн бага оврын трактор худалдан авах", "Газар тариалангийн зориулалттай зарим техник, тоног төхөөрөмж худалдан авах төсөл"-ийн гэрээнүүдийн хугацаа хэтэрч хуримтлагдсан төлбөр 2025 оны байдлаар 47,425.1 сая төгрөг болж нэмэгдсэн, 2025 оны хуваарьт төлөлт 10,599.1 сая төгрөгөөс 6,945.7 сая төгрөгийг төлөөгүй;
3) “Хөдөө аж ахуйн корпораци” ТӨХХК болон "Д" ХХК-ийн хооронд байгуулсан "Санхүүгийн түрээсийн өр төлбөр барагдуулах "ӨТБГ-23/01 дугаартай гэрээний хугацаа хэтэрсэн 23,240.5 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдлийг барагдуулаагүй;
4) Иргэн хуулийн этгээдэд түрээсийн гэрээгээр 7 жилийн хугацаатай эзэмшүүлж, ашиглуулж байгаа, нийт 2,570.2 сая төгрөгийн дансны үнэ бүхий бусад үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 5 нэр төрлийн 78 ширхэг техник, тоног төхөөрөмжийн гэрээг бүрэн дүгнээгүй, тооцоо нийлж баталгаажуулаагүй, гэрээнд заасны дагуу 2,475.5 сая төгрөгийн хөрөнгийг буцаан төвлөрүүлээгүй;
5) 2024 онд аж ахуйн нэгж байгууллагын хугацаа хэтэрсэн өр төлбөрт хүлээн авсан нийт 15.5 сая төгрөгийн дансны үнэ бүхий 8 толгой үхэр дутсаныг бүрэн шийдвэрлүүлээгүй;
6) Бусад биет бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй Хөтөл салбарын эзэмшлийн гахайн өвлийн байрны зориулалттай 4730м.кв талбайтай газрын эзэмших эрх хүчингүй болсон, мөн төмс, хүнсний ногооны зориулалттай 1.8 га талбайтай, нийт 11.6 сая төгрөгийн газар хувь хүний нэр дээр бүртгэлтэй хэвээр байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-т “*Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно”*, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журмын 19.1-т *"Шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах"* гэж тус тус заасныг зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь:* Өмнөх аудитын шийдвэрийг биелүүлээгүй албан тушаалтнуудад хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулах албан шаардлага хүргүүлэв.

*8. Илрүүлэлт:* Өмнөх оны аудитаар өгсөн дараах зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна. Үүнд:

1) “Хөдөө аж ахуйн корпораци” ТӨХХК нь газар тариалангийн бүс нутагт түшиглэсэн 6 салбарт нийт 180 мянган тонн үр тариа хадгалах зориулалт бүхий элеватор, агуулахыг эзэмшиж, улаанбуудай, малын тэжээлийн нөөцийг бүрдүүлж байгаа боловч тэдгээр элеватор, агуулахад дулаан мэдрэгч, жингийн хэмжигч суурилуулах, шаардлагатай засвар үйлчилгээний зардлыг хөрөнгө оруулалтад төлөвлөөгүй, үе шаттайгаар шийдвэрлээгүй;
2) Компанийн тайлант оны үрийн болон тэжээлийн улаанбуудайн борлуулалтын гэрээний үүргийн хэрэгжилт хангалтгүйгээс үрийн улаанбуудайн 1,757.3 сая төгрөг, тэжээлийн улаанбуудайн 1,459.9 сая төгрөг, нийт 3,217.2 сая төгрөгийн авлага төлөгдөөгүй үлдэгдэлтэй;
3) Тодорхой бус өр төлбөрийн 385.0 сая үлдэгдэл бүртгэлтэй байгааг анхан шатны баримттай тулган баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д *“Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”*, 20 дугаар зүйлийн 20.2.5-д *“Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”*, 20.2.6-д *“Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”*, Засгийн Газрын 2021 оны 394 дүгээр *тогтоолоор баталсан "Хөдөө аж ахуйн корпораци" ТӨХХК-ийн дүрмийн 5.2.11-д "Үйлдвэрлэлийн менежментийг сайжруулан элеватор, агуулахын ариутгал, халдваргүйжүүлэлт хийх, шаардлагатай засварууд, худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулж, улаанбуудай, малын тэжээлийн хадгалалтын нөхцөлийг сайжруулах"* гэж тус тус заасныг зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь:* Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

### 5.2.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Бараа материалтай холбоотой асуудал***

Хөдөө аж ахуйн корпораци ТӨХХК-ийн Сэлэнгэ салбараас Шим үр ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр зөвшөөрөлгүй нийлүүлсэн 45.7 сая төгрөгийн, 65.29 тн будааг борлуулалтаар тусгаагүй, биетээр оршин байхгүй нь 2025 оны эхний хагас жилийн тооллогоор илэрсэн боловч "2021 оны 4-р ангилал"-ын буудайны дансанд бүртгэлтэй хэвээрээ, зохих арга хэмжээг авч ажиллаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д *"Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1-д "Аж ахуйн бүх ажил, гүйлгээ"*, 14.4.5-д *"Бүх орлого"*, 5 дугаар зүйлийн 5.1-д *"Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална"*, 5.1.3-д *"Жинхэнэ хэрэгжилтийн"*, 5.1.4-т *"Үнэн зөв байх"*, 20 дугаар зүйлийн 20.2.6-д *"Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах"* гэж тус тус заасныг зөрчсөн байна.

*Өгсөн зөвлөмж:* Анхан шатны баримтын бүрдэл хангасан, зохих зөвшөөрөлтэйгөөр улаанбуудайг агуулахаас гаргаж харилцагчид олгож байх, бараа материалд тавих хяналтыг сайжруулах.

***2. Бараа материалтай холбоотой асуудал***

Хархорин салбарын 2025 оны жилийн эцсийн 40.14 тн улаанбуудайн хэвийн хорогдлыг бүртгэлд тусгаагүйгээс тооллогын үлдэгдэл нь санхүүгийн тайланд тусгасан бараа материалын үлдэгдлээс 44.3 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д *"Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах"* гэж заасныг зөрчсөн байна.

*Өгсөн зөвлөмж:* Бараа материалын хэвийн хорогдлыг тодорхойлсон тухай бүрт бүртгэлд тусгаж байх.

***3. Бараа материалтай холбоотой асуудал***

Улаан буудайг анх хүлээн авахдаа хариуцлагагүй хандаж ангилал хооронд хольж хадгалсны улмаас жилийн эцсийн тооллогоор 2022-2025 оны 4 ангиллын улаан буудайнаас 8 төрлийн 1,194.3 тонн дутуу, 6 төрлийн 771.8 тонн илүүдсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.2-т *"Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана"* гэж заасныг зөрчсөн байна.

*Өгсөн зөвлөмж:* Бараа материалыг агуулахад эмх цэгцтэй хадгалах, тооллогын үр дүнг тухай бүрт шийдвэрлэж байх.

***4. Авлагатай холбоотой асуудал***

Ипотекийн зээлийн шалгуур хангаагүй, ЖДҮХАгентлагт ажилладаг 3 иргэний орон сууцны урьдчилгаа төлбөрт төлсөн 210.9 сая төгрөгийг Өгөөж гурил ХХК-аас авах авлагаар бүртгэсэн ба барагдуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д *"Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах"* гэж заасныг зөрчсөн байна.

*Өгсөн зөвлөмж:* Үндсэн үйл ажиллагаанаас үүсээгүй авлагыг барагдуулах.

***5. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал***

Тус байгууллагын үндсэн хөрөнгийн бүртгэлд 12,815.2 сая төгрөгийн анхны өртгөө элэгдлээрээ бүрэн нөхсөн, үлдэх өртөггүй, 3017 нэр төрлийн үндсэн хөрөнгийг цаашид ашиглах болон дахин үнэлүүлэн бодит үнэ цэнээр бүртгэх асуудлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх саналыг хүргүүлээгүй байна.

Энэ нь ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолын 7 дугаар зүйлийн 7.1-д *“Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг ТӨБЗГ-т ирүүлж шийдвэрлүүлнэ*” гэж заасныг зөрчсөн байна.

*Өгсөн зөвлөмж:* Анхны өртгөө элэгдлээрээ нөхсөн хөрөнгүүдийг ашиглах хугацааг сунгах, үнийг шинэчлэн тогтоох саналаа холбогдох байгууллагад хүргүүлж, шийдвэрлүүлэх.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Бараа материалын дансанд бүртгэлтэй Хөтөл 2565 тонн , Угтаал 2300 тонн, нийт 4865 тонн, 2,965.4 сая төгрөгийн улаанбуудайг 2026 онд борлуулахаар тохирсон хэрэгжээгүй борлуулалтын ББӨртгийг бүртгэж бараа материалын дансны үлдэгдлийг бодит бусаар бууруулан тайлагнасан. | 1 | 2,147,471.0 | | | | | 1 | 2,147,471.0 | | | | |
| Санхүүгийн программын автомат үйлдлийг хянаагүйгээс харилцагчийн дансны үлдэгдэлд бодит бус 382.4 сая төгрөгийн алданги тооцсон. | 1 | 382,436.9 | | | | | 1 | 382,436.9 | | | | |
| Улаанбаатар гурил ХХК-д улаанбуудайгаар төлөх өглөгийн үлдэгдлийг 2,965.4 сая төгрөгөөр дутуу илэрхийлсэн. | 1 | 2,965,384.7 | | | | | 1 | 2,965,384.7 | | | | |
| Шүүхийн шийдвэрийн дагуу эрх бүхий албан тушаалтны буруугаас чөлөөлөгдсөн 2 ажилтанд олгосон 111.8 сая төгрөгийн нөхөн төлбөрийг байгууллагын зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна. | 1 | 111,813.9 | | | | | 1 | 111,813.9 | | | | |
| Тайлант хугацаанд тооцсон үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг 0.3 сая төгрөгөөр дутуу тооцсон. | 1 | 383.9 | | | | | 1 | 383.9 | | | | |
| Хөдөө аж ахуйн таримал сорт сорих ажил гүйцэтгэх гэрээт ажлын зардал болон харилцагчид төлөх дансны өглөгийг 71.4 сая төгрөгөөр тус тус илүү илэрхийлсэн. | 1 | 71,400.0 | | | | | 1 | 71,400.0 | | | | |
| Удирдлагын шатахуун, салбаруудын сэлбэг материалын зэрэг 202.3 сая төгрөгийн зардлыг бусад зардлаар илэрхийлсэн байна. | 1 | 202,335.3 | | | | | 1 | 202,335.3 | | | | |
| Аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж өмнөх онд худалдан авсан 419.7 сая төгрөгийн биет бус хөрөнгийг 2024 оны зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэснийг залруулахдаа 2025 оны тайлант үеийн үр дүнг бууруулсан байна. | 1 | 419,650.0 | | | | | 1 | 419,650.0 | | | | |
| | **8** | **6,300,875.7** | | | | | **8** | **6,300,875.7** | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| № | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс: Төлбөрийн акт | | Үүнээс: Албан шаардлага | | Үүнээс: Зөвлөмж | | Үүнээс: Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Үүнээс: Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| 1 | Хөдөө аж ахуйн корпораци ТӨХХК-ийн Угтаал салбарын 2025 оны хөрөнгийн тооллогоор үүссэн 402,458.0 сая төгрөгийн 423.64 тонн хэмжээтэй будааны дутагдлыг шийдвэрлээгүй байна. | 1 | 402,458.0 | | | 1 | 402,458.0 | | | | | | |
| 2 | Тус байгууллагын бараа материалын дансанд бүртгэлтэй 389,175.2 мянган төгрөгийн үр тарианы ургамал хамгаалалын бодис, 551,903.3 мянган төгрөгийн төмс хүнсний ногооны ургамал хамгааллын бодисны хадгалах хугацаа дууссан цаашид худалдан борлуулах боломжгүй болсон байна | 1 | 941,078.5 | | | 1 | 941,078.5 | | | | | | |
| 3 | Бүртгэлтэй хаяган дээрээ байхгүй 252 харилцагчийн 4,123,891.7 мянган төгрөгийн, татан буугдсан 43 харилцагчийн 633,129.0 мянган, эзэн холбогдогч нь нас барсан 80 харилцагчийн 388,935.8 мянган авлагуудыг ТУЗ-өөр шийдвэрлүүлээгүй байна. | 1 | 5,145,956.5 | | | 1 | 5,145,956.5 | | | | | | |
| 4 | Шүүхийн шийдвэрээр эрх бүхий албан тушаалтны буруугаас ажлаас чөлөөлөөгдсөн 2 ажилтанд төлсөн 111,813.9 мянган төгрөгийн нөхөн төлбөрийг буруутай албан тушаалтанаар төлүүлээгүй байна. | 1 | 111,813.9 | | | 1 | 111,813.9 | | | | | | |
| 5 | Тус байгууллагаас Орон сууцны урьдчилгаанд 2012 онд 4 ажилтанд өгсөн 80,000.0 мянган төгрөг, 2025 онд Хөдөө аж ахуйн яамны ажлаас чөлөөлөгдсөн 1 ажилтантай холбоотой орон сууцны | 1 | 156,813.5 | | | 1 | 156,813.5 | | | | | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | зээлийн урьдчилгаа төлбөрт төлсөн 76,813.5 мянган төгрөгийн авлагыг барагдуулах талаар арга хэмжээ аваагүй байна. | | | | | | | | | | | | |
| 6 | Тайлант онд 3144 харилцагчдаас авах 44,002,744.1 мянган авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажаагүй байна. | 1 | 44,002,744.1 | | | 1 | 44,002,744.1 | | | | | | |
| 7 | 1) “Б” ХХК-тай 2024 онд байгуулсан улаанбуудайг худалдах АҮ/65, АҮ/102 дугаартай гэрээнүүдийн 7,273,308.6 мянган төгрөгийн төлбөрийг барагдуулах тухай шүүгчийн захирамжаар “Хөдөө аж ахуйн корпораци” ТӨХХК нь алдангиас татгалзаж эвлэрсэн боловч, "Б" ХХК нь 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдөр 200,000.0 мянган төгрөг төгрөгийн төлбөрийг хуваарийн дагуу төлөөгүй;<br>2) Сангийн яам, ХХААХҮЯ хооронд 2013 онд анхлан байгуулж 2020 онд шинэчилсэн "Хөдөө аж ахуйн бага оврын трактор худалдан авах", "Газар тариалангийн зориулалттай зарим техник, тоног төхөөрөмж худалдан авах төсөл"-ийн гэрээнүүдийн хугацаа хэтэрч 47,425,128.2 мянган төгрөг болж нэмэгдсэн, 2025 оны хуваарьт төлөлтөөс 6,945,691.1 мянган төгрөгийг төлөөгүй;<br>3) “Хөдөө аж ахуйн корпораци” ТӨХХК болон "Д" ХХК-ийн хооронд байгуулсан "Санхүүгийн түрээсийн өр төлбөр барагдуулах” гэрээний хугацаа хэтэрсэн 23,240,512.4 мянган төгрөгийн өр төлбөрийн барагдуулаагүй;<br>4) Иргэн хуулийн этгээдэд түрээсийн гэрээгээр 7 жилийн хугацаатай эзэмшүүлж, ашиглуулж байгаа, нийт 2,570,217.9 мянган төгрөгийн дансны үнэ бүхий 78 ширхэг техник, тоног төхөөрөмжийн гэрээг бүрэн дүгнээгүй, тооцоо нийлж баталгаажуулаагүй, гэрээнд заасны дагуу 2,475,517.9 мянган төгрөгийн хөрөнгийг буцаан төвлөрүүлээгүй;<br>5) 2024 онд аж ахуйн нэгж байгууллагын хугацаа хэтэрсэн өр | 1 | 86,987,278.2 | | | | | | | 1 | 86,987,278.2 | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | төлбөрт хүлээн авсан нийт 15,500.0 мянган төгрөгийн дансны үнэ бүхий 8 толгой үхэр дутсаныг бүрэн шийдвэрлүүлээгүй;<br>6) Бусад биет бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй Хөтөл салбарын эзэмшлийн нийт 11,620.0 мянган төгрөгийн газар хувь хүний нэр дээр бүртгэлтэй хэвээр байна. | | | | | | | | | | | | |
| 8 | 1) “Хөдөө аж ахуйн корпораци” ТӨХХК нь газар тариалангийн бүс нутагт түшиглэсэн 6 салбарт нийт 180 мянган тонн үр тариа хадгалах зориулалт бүхий элеватор, агуулахыг эзэмшиж, улаанбуудай, малын тэжээлийн нөөцийг бүрдүүлж байгаа боловч тэдгээр элеватор, агуулахад дулаан мэдрэгч, жингийн хэмжигч суурилуулах, шаардлагатай засвар үйлчилгээний зардлыг хөрөнгө оруулалтад төлөвлөөгүй, үе шаттайгаар шийдвэрлээгүй;<br>2) Компанийн тайлант оны үрийн болон тэжээлийн улаанбуудайн борлуулалтын гэрээний үүргийн хэрэгжилт хангалтгүйгээс үрийн улаанбуудайн 1,757,335.2 мянган төгрөг, тэжээлийн улаанбуудайн 1,459,892.0 мянган төгрөг, нийт 3,217,227.2 мянган төгрөгийн авлага төлөгдөөгүй үлдэгдэлтэй;<br>3) Тодорхой бус өр төлбөрийн 384,985.5 мянган төгрөгийн үлдэгдэл бүртгэлтэй байгаа анхан шатны баримттай тулган баталгаажуулаагүй байна. | 1 | 3,602,212.7 | | | 1 | 3,602,212.7 | | | | | | |
| 9 | Сэлэнгэ салбараас Шим үр ХХК-д 2024 онд зөвшөөрөлгүй нийлүүлсэн 45,703.0 мянган төгрөгийн, 65.29 тн будааг борлуулалтаар тусгаагүй, биетээр оршин байхгүй нь 2025 оны эхний хагас жилийн тооллогоор илэрсэн боловч "2021 оны 4-р ангилал"-ын буудайны дансанд бүртгэлтэй хэвээрээ, зохих арга хэмжээг авч ажиллаагүй байна. | 1 | 45,703.0 | | | | | 1 | 45,703.0 | | | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 10 | Хархорин салбарын 2025 оны жилийн эцсийн 40.14 тн улаанбуудайн хэвийн хорогдлыг бүртгэлд тусгаагүйгээс тооллогын үлдэгдэл нь санхүүгийн тайланд тусгасан бараа материалын үлдэгдлээс 44,346.5 мянган төгрөгөөр зөрсөн байна. | 1 | 44,346.5 | | | | | 1 | 44,346.5 | | | | |
| 11 | Улаан буудайг анх хүлээн авахдаа ангилал хооронд хольж хадгалснаас жилийн эцсийн тооллогоор 2022-2025 оны 4 ангиллын улаан буудайнаас 8 төрлийн 1,194.3 тонн дутуу, 6 төрлийн 771.8 тонн илүүдсэн байна. | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| 12 | Ипотекийн зээлийн шалгуур хангаагүй, ЖДҮХАгентлагт ажилладаг 3 иргэний орон сууцны урьдчилгаа төлбөрт төлсөн 210,900.0 мянган төгрөгийг Өгөөж гурил ХХК-иас авах авлагаар бүртгэсэн ба барагдуулаагүй байна. | 1 | 210,900.0 | | | | | 1 | 210,900.0 | | | | |
| 13 | Тус байгууллагын үндсэн хөрөнгийн бүртгэлд 12,815.2 сая төгрөгийн анхны өртгөө элэгдлээрээ бүрэн нөхсөн, үлдэх өртөггүй, 3017 нэр төрлийн үндсэн хөрөнгийг цаашид ашиглах болон дахин үнэлүүлэн бодит үнэ цэнээр бүртгэх асуудлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх саналыг хүргүүлээгүй байна. | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| **Нийт дүн** | | **13** | **141,651,304.9** | **-** | **-** | **7** | **54,363,077.2** | **5** | **300,949.5** | **1** | **86,987,278.2** | **-** | **-** |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| № | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | **Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил** | | | | | | |
| 1 | Гүйцэтгэх захирлын 2023 оны А/107 дугаартай тушаалыг Сэлэнгэ салбар нь 2023, 2024 онуудад хэрэгжүүлээгүй, 2025 оны үнэ төлбөргүй гарсан зардалд тайлагнасан байна. | 1 | - | | | 1 | - |
| 2 | Тайлант онд намрын буудайн хатаалгын шатахуун нийлүүлэгчийг сонгохдоо тендерийн баримт бичигт заасан "Бүтээгдэхүүн нийлүүлэлтийн хуваарь"-г ирүүлээгүй оролцогч байгууллагыг шалгаруулсан. | 1 | 412,140.0 | | | 1 | 412,140.0 |
| **Нийт дүн** | | **2** | **412,140.0** | | | **2** | **412,140.0** |

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 03 сарын 16 өдөр Дугаар 784/А0150079 Улаанбаатар хот

САГ-2026/82/ИА-СТА-ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөдөө аж ахуйн корпораци ТӨХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хөдөө аж ахуйн корпораци ТӨХХК-ийн Угтаал салбарын 2025 оны хөрөнгийн тооллогоор үүссэн 402,458,000.00 /Дөрвөн зуун хоёр сая дөрвөн зуун тавин найман мянган/ төгрөгийн 423.64 тонн хэмжээтэй будааны дутагдлыг шийдвэрлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.2-т "Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн А/95 дугаар тушаалын хавсралтын Хоёрдугаар бүлгийн 4-ийн 4.2.1.1 "Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Тооллогоор үүссэн дутагдлыг шийдвэрлээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөө аж ахуйн корпораци ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал /Б.Цогтсаран/, нягтлан бодогч /Б.Сосорбарам/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

| | |
|---|---|
| САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР | Ц.НАРАНЧИМЭГ |
| АУДИТЫН МЕНЕЖЕР | Э.ЭНХБААТАР |
| ПИЙК ОМ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР | А.МӨНХЦЭЦЭГ |

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

Z:\Alban Shaardlaga\2026\0316 SAG-46.Docx

1526181031

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр Дугаар 785/А0150079 Улаанбаатар хот

САГ-2026/82/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөдөө аж ахуйн корпораци ТӨХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллагын бараа материалын дансанд бүртгэлтэй үр тарианы ургамал хамгааллын бодис 12,042.94 литр 389,175,203.66 /Гурван зуун наян есөн сая нэг зуун далан таван мянга хоёр зуун гурван төгрөг жаран зургаан мөнгө/-ийн, төмс хүнсний ногооны ургамал хамгааллын бодис 8.239.5 литр 551,903,270.95 /Таван зуун тавин нэгэн сая есөн зуун гурван мянга хоёр зуун далан төгрөг ерэн таван мөнгө/-ийн хөрөнгийн ашиглалтын хугацаа дууссан цаашид худалдан борлуулах боломжгүй болсон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "*Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.*", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "*эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;*", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-д "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх бариг нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн А/95 дугаар тушаалын хавсралтын Хоёрдугаар бүлгийн 4-ийн 4.2.1.4 "Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Бараа материалын худалдан авалтыг оновчтой төлөвлөөгүй, ашиглалтын хугацаанд хяналт тавиагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөө аж ахуйн корпораци ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал /Б.Цогтсаран/, нягтлан бодогч /Б.Сосорбарам/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН<br>
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ<br>
АУДИТЫН МЕНЕЖЕР Э.ЭНХБААТАР<br>
ПИЙК ОМ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР А.МӨНХЦЭЦЭГ

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

Z:\Alban Shaardlaga\2026\0316 SAG-46.Docx

1526181032

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр Дугаар 786/А0150079 Улаанбаатар хот

САГ-2026/82/ИА-СТА-ТӨҮГ

Зөрчил арилгаж тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөдөө аж ахуйн корпораци ТӨХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бүртгэлтэй хаяган дээрээ байхгүй 252 харилцагчийн 4,123,891,746.76 /Дөрвөн тэрбум нэг зуун хорин гурван сая найман зуун ерэн нэгэн мянга долоон зуун дөчин зургаан төгрөг далан зургаан мөнгө/-ийн, татан буугдсан 43 харилцагчийн 633,128,968.20 /Зургаан зуун гучин гурван сая нэг зуун хорин найман мянга есөн зуун жаран найман төгрөг хорин мөнгө/-ийн, эзэн холбогдогч нь нас барсан 80 харилцагчийн 388,935,786.36 /Гурван зуун наян найман сая есөн зуун гучин таван мянга долоон зуун наян зургаан төгрөг гучин зургаан мөнгө/-ийн авлагуудыг ТУЗ-өөр шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн А/95 дугаар тушаалын хавсралтын Хоёрдугаар бүлгийн 4-ийн 4.2.1.11 “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал”-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Барагдуулаагүй авлагуудыг Хөдөө аж ахуйн корпораци ТӨХХК-ийн ТУЗ-д хандан шийдвэрлүүлээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөө аж ахуйн корпораци ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал /Б.Цогтсаран/, нягтлан бодогч /Б.Сосорбарам/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР Э.ЭНХБААТАР
ПИЙК ОМ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР А.МӨНХЦЭЦЭГ

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

Z:\Alban Shaardlaga\2026\0316 SAG-46.Docx

1526181034

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 03 сарын 16 өдөр Дугаар 787/A0150079 Улаанбаатар хот

САГ-2026/82/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил арилгах зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөдөө аж ахуйн корпораци ТӨХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шүүхийн шийдвэрээр эрх бүхий албан тушаалтны буруугаас ажлаас чөлөөлөгдсөн 2 ажилтанд төлсөн 111,813,878.00 /Нэг зуун арван нэгэн сая найман зуун арван гурван мянга найман зуун далан найман/ төгрөгийн нөхөн төлбөрийг буруутай албан тушаалтнаар төлүүлээгүй байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-т "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ", 103.2-т "Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай этгээдээр хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн А/95 дугаар тушаалын хавсралтын Хоёрдугаар бүлгийн 4-ийн 4.2.1.11 “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал”-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Албан тушаалтны буруутай шийдвэрийн улмаас байгууллагад учирсан хохирлыг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх арга хэмжээ аваагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэрийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитыг газарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР Э.ЭНХБААТАР

ПИЙК ОМ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР А.МӨНХЦЭЦЭГ

9006102
АТА16087
9025031411

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

Z:\Alban Shaardlaga\2026\0316 SAG-46.Docx

1526181036

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 03 сарын 16 өдөр Дугаар 788/А0150079 Улаанбаатар хот

САГ-2026/82/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөдөө аж ахуйн корпораци ТӨХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллагаас Орон сууцны урьдчилгаанд 2012 онд 4 ажилтанд өгсөн 80,000,000.00 /Наян сая/ төгрөг, 2025 онд Хөдөө аж ахуйн яамны ажлаас чөлөөлөгдсөн 1 ажилтантай холбоотой орон сууцны зээлийн урьдчилгаа төлбөрт төлсөн 76,813,500.00 /Далан зургаан сая найман зуун арван гурван мянган таван зуун/ төгрөгийн авлагыг барагдуулах талаар арга хэмжээ аваагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д *"эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;"* гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн А/95 дугаар тушаалын хавсралтын Хоёрдугаар бүлгийн 4-ийн 4.2.1.11 "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөө аж ахуйн корпораци ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал /Б.Цогтсаран/, нягтлан бодогч /Б.Сосорбарам/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР Э.ЭНХБААТАР

ПИЙК ОМ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР А.МӨНХЦЭЦЭГ

9006109
АТА16087
9025081411

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

*Z:\Alban Shaardlaga\2026\0316 SAG-46.Docx*

1526181038

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 03 сарын 16 өдөр Дугаар 789/А0150079 Улаанбаатар хот

САГ-2026/82/ИА-СТА-ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөдөө аж ахуйн корпораци ТӨХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 3144 харилцагчдаас авах 44,002,744,069.82 /Дөчин дөрвөн тэрбум хоёр сая долоон зуун дөчин дөрвөн мянга жаран есөн төгрөг наян хоёр мөнгө/-ийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "*Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.*", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;*", 20.2.6-д "*эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;*", гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн А/95 дугаар тушаалын хавсралтын Хоёрдугаар бүлгийн 4-ийн 4.2.1.7 "Авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөө аж ахуйн корпораци ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал /Б.Цогтсаран/, нягтлан бодогч /Б.Сосорбарам/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР Э.ЭНХБААТАР
ПИЙК ОМ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР А.МӨНХЦЭЦЭГ

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

Z:\Alban Shaardlaga\2026\0316 SAG-46.Docx

1526181040

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 03 сарын 16 өдөр Дугаар 790/A0150079 Улаанбаатар хот

САГ-2026/82/ИА-СТА-ТӨҮГ

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөдөө аж ахуйн корпораци ТӨХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Аудитаар өгсөн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүйгээс

1. "Б" ХХК-тай 2024 онд байгуулсан улаанбуудайг худалдах АҮ/65, АҮ/102 дугаартай гэрээнүүдийн 7,273,308,550.00 /Долоон тэрбум хоёр зуун далан гурван сая гурван зуун найман мянга таван зуун тавин/ төгрөгийн төлбөрийг барагдуулах тухай Дархан-Уул аймгийн сум дундын анхан шатны шүүхийн шүүгчийн 2025 оны 12 сарын 01-ний өдрийн 307/ШШ2025/02348 дугаартай "Зохигчийн эвлэрлийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгох тухай" захирамжаар "Хөдөө аж ахуйн корпораци" ТӨХХК нь 3,641.4 сая төгрөгийн алдангиас татгалзаж эвлэрсэн боловч, "Б" ХХК нь 2025 оны 11 сарын 17-ны өдрийн төлбөрийг төлсөн боловч 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдөр 200,000,000.00 /Хоёр зуун сая/ төгрөг төгрөгийн төлбөрийг захирамжийн хуваарийн дагуу төлөөгүй;
2. Сангийн яам, ХХААХҮЯ хооронд 2013 онд анхлан байгуулж 2020 онд шинэчилсэн "Хөдөө аж ахуйн бага оврын трактор худалдан авах", "Газар тариалангийн зориулалттай зарим техник, тоног төхөөрөмж худалдан авах төсөл"-ийн гэрээнүүдийн хугацаа хэтэрч хуримтлагдсан төлбөр 2025 оны байдлаар 47,425,128,227.00 /Дөчин долоон тэрбум дөрвөн зуун хорин таван сая нэг зуун хорин найман мянга хоёр зуун хорин долоон/ төгрөг болж нэмэгдсэн, 2025 оны хуваарьт төлөлт 10,599,143,150.00 /Арван тэрбум таван зуун ерэн есөн сая нэг зуун дөчин гурван мянга нэг зуун тавин/ төгрөгөөс 6,945,691,097.00 /Зургаан тэрбум есөн зуун дөчин таван сая зургаан зуун ерэн нэгэн мянга ерэн долоон/ төгрөгийг төлөөгүй;
3. "Хөдөө аж ахуйн корпораци" ТӨХХК болон "Д" ХХК-ийн хооронд байгуулсан "Санхүүгийн түрээсийн өр төлбөр барагдуулах "ӨТБГ-23/01 дугаартай гэрээний хугацаа хэтэрсэн 23,240,512,404.57 /Хорин гурван тэрбум хоёр зуун дөчин сая таван зуун арван хоёр мянга дөрвөн зуун дөрвөн төгрөг тавин долоон мөнгө/-ийн өр төлбөрийн үлдэгдлийг барагдуулаагүй;
4. Иргэн хуулийн этгээдэд түрээсийн гэрээгээр 7 жилийн хугацаатай эзэмшүүлж, ашиглуулж байгаа, нийт 2,570,217,942.74 /Хоёр тэрбум таан зуун далан сая хоёр зуун арван долоон мянган есөн зуун дөчин хоёр төгрөг далан дөрвөн мөнгө/-ийн дансны үнэ бүхий бусад үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 5 нэр төрлийн 78 ширхэг техник, тоног төхөөрөмжийн гэрээг бүрэн дүгнээгүй, тооцоо нийлж баталгаажуулаагүй, гэрээнд заасны дагуу 2,475,517,942.74 /Хоёр тэрбум дөрвөн зуун далан таван сая таван зуун арван долоон мянга есөн зуун дөчин хоёр төгрөг далан дөрвөн мөнгө/-ийн хөрөнгийг буцаан төвлөрүүлээгүй;
5. 2024 онд аж ахуйн нэгж байгууллагын хугацаа хэтэрсэн өр төлбөрт хүлээн авсан нийт 15,500,000.00 /Арван таван сая таван зуун мянган/ төгрөгийн дансны үнэ бүхий 8 толгой үхэр дутсаныг бүрэн шийдвэрлүүлээгүй;
6. Бусад биет бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй Хөтөл салбарын эзэмшлийн гахайн өвлийн байрны зориулалттай 4730м.кв талбайтай газрын эзэмших эрх хүчингүй болсон, мөн төмс, хүнсний ногооны зориулалттай 1.8 га талбайтай, нийт 11,620,000.00 /Арван нэгэн сая зургаан зуун хорин мянган/ төгрөгийн газар хувь хүний нэр дээр бүртгэлтэй хэвээр байна.

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т “Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөх талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ” гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмнөх аудитын шийдвэрийг биелүүлээгүй Хөдөө аж ахуйн корпораци ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал Б.Цогтсаран, нягтлан бодогч Б.Сосорбарам нарт заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж 2026 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Хөдөө аж ахуйн корпораци ТӨХХК-ийн ТУЗ-ийн Аудитын хороонд даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР Э.ЭНХБААТАР
ПИЙК ОМ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР А.МӨНХЦЭЦЭГ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 03 сарын 16 өдөр    Дугаар 791/А0150079    Улаанбаатар хот

САГ-2026/82/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөдөө аж ахуйн корпораци ТӨХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй,

1. “Хөдөө аж ахуйн корпораци” ТӨХХК нь газар тариалангийн бүс нутагт түшиглэсэн 6 салбарт нийт 180 мянган тонн үр тариа хадгалах зориулалт бүхий элеватор, агуулахыг эзэмшиж, улаанбуудай, малын тэжээлийн нөөцийг бүрдүүлж байгаа болович тэдгээр элеватор, агуулахад дулаан мэдрэгч, жингийн хэмжигч суурилуулах, шаардлагатай засвар үйлчилгээний зардлыг хөрөнгө оруулалтад төлөвлөөгүй, үе шаттайгаар шийдвэрлээгүй;
2. Компанийн тайлант оны үрийн болон тэжээлийн улаанбуудайн борлуулалтын гэрээний үүргийн хэрэгжилт хангалтгүйгээс үрийн улаанбуудайн 1,757,335,191.00 /Нэг тэрбум долоон зуун тавин долоон сая гурван зуун гучин таван мянган нэг зуун ерэн нэгэн/ төгрөг, тэжээлийн улаанбуудайн 1,459,892,000.00 /Нэг тэрбум дөрвөн тавин есөн сая найман зуун ерэн хоёр мянган/ төгрөг, нийт 3,217,227,191.00 /Гурван тэрбум хоёр зуун арван долоон сая хоёр зуун хорин долоон мянга нэг зуун ерэн нэгэн/ төгрөгийн авлага төлөгдөөгүй үлдэгдэлтэй;
3. Тодорхой бус өр төлбөрийн 384,985,471.90 /Гурван зуун наян дөрвөн сая есөн зуун наян таван мянга дөрвөн зуун далан нэгэн төгрөг ерэн мөнгө/-ийн үлдэгдэл бүртгэлтэй байгааг анхан шатны баримттай тулган баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.*”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;*”, 20.2.6-д “*эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;*”, Засгийн Газрын 2021 оны 394 дүгээр тогтоолоор баталсан "Хөдөө аж ахуйн корпораци" ТӨХХК-ийн дүрмийн 5.2.11-д "Үйлдвэрлэлийн менежментийг сайжруулан элеватор, агуулахын ариутгал, халдваргүйжүүлэлт хийх, шаардлагатай засварууд, худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулж, улаанбуудай, малын тэжээлийн хадгалалтын нөхцөлийг сайжруулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн А/95 дугаар тушаалын хавсралтын Хоёрдугаар бүлгийн 4-ийн 4.2.1.10 “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол”-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

1. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөө аж ахуйн корпораци ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал /Б.Цогтсаран/, нягтлан бодогч /Б.Сосорбарам/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР Э.ЭНХБААТАР
ПИЙК ОМ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР А.МӨНХЦЭЦЭГ

9005109
АТА16037
9035081411